



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 17

Сүхбаатар

Төрийн албаны мэргэшлийн шалгалтын
дүнг уламжлах тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1.2017 оны 10 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтанд 295 иргэн бүртгүүлж 275 иргэн оролцож 92 иргэн тэнцсэнээс 38 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 54 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгүүлэхээр 1,2 дугаар хавсралтаар баталж Төрийн албаны зөвлөлд уламжилсугай.

2.Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 6 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 12 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь нэр дэвшүүлэхээр 3,4 дүгээр хавсралтаар баталж Төрийн албаны зөвлөлд уламжилсугай.

3.Төрийн албаны шалгалт зохион байгуулсан тухай илтгэх хуудас, хяналтын хуудас, шалгалтын дүн мэдээг боловсруулан хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Төрийн албаны мэргэшлийн шалгалтын салбар комиссын нарийн бичгийн дарга /Б.Ариундэлгэр/-д даалгасугай.

ДАРГА



Ө.СУВДАА